

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах хяналтын чадавхыг бэхжүүлэх ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Олон Улсын хамтын ажиллагааны “ЖАЙКА” байгууллага

НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫН АСУУДАЛ
ХАРИУЦСАН ОРЛОГЧ Т.ТӨМӨРТӨӨМӨӨ

Агуулга

1 Төслийн товч танилцуулга

2 Төслийн зорилго, зорилт

3 Төслийн хэрэгжилтийн үе шатууд

4 Төслийн 3-р үе шаттай холбоотой

4.1 Төслийн явц

4.2 Сайжруулсан шахмал түлшний загвар төсөл

4.3 РМ химийн найрлагын шинжилгээнд тулгуурласан эх үүсвэрийн нөлөөллийн дүн шинжилгээ

4.4 Автотээврийн хэрэгслээс үүдэлтэй бохирдлыг бууруулах арга хэмжээ

1. Төслийн товч танилцуулга

Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах зорилгоор Монгол улсын Засгийн газар Япон улсын Засгийн газарт хүсэлт гаргаснаар Олон Улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллагаас “Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийг 3 үе шаттайгаар хэрэгжүүлээд байна.




2. Төслийн эрхэм зорилго, зорилт

Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулж, голлох эх үүсвэрүүдээс ялгарах бохирдуулах бодисын ялгарлыг бууруулна. Агаарын бохирдлыг бууруулах талаар үр дүнтэй арга хэмжээний хэрэгжилт, НАБТГ, төрийн болон нийслэлийн холбогдох байгууллагын хамтын ажиллагааг сайжруулахад голлон анхаарч, УБ хотын агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх чадавхыг сайжруулах.



3. Төслийн хэрэгжилтийн үе шатууд





1

Үр дүн

SO₂, PM₁₀, CO болон NO₂-ын тархалтын загварчлалын зураглал 2010-2011 он

Төсөл 1-р үе шат

Үр дүн 1



Эх үүсвэрийн ялгарлын инвенторын гарын авлагыг гарган, тархалтын загварчлалын моделийг боловсруулан цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулсан.

Үр дүн 2



ДЦС-ын зуух, УХЗ, Гэрийн зууханд нийт 201 удаагын утааны хийн хэмжилт хийж, төлөвлөсний дагуу утааны хийн хэмжилтийн техникийн ур чадавхийг эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулан холбогдох гарын авлагыг боловсруулсан.

Үр дүн 3



Зуухны бүртгэл, хяналтын тогтолцооны маягыг боловсруулан мэдээллийн сан үүсгэж, түүнд тулгуурлан жил бүл тооллого хийх эрх зүйн баримт бичигтэй болсон

Үр дүн 4



702 сая төгрөгийн багаж төхөөрөмж нийлүүлсэн.

Үр дүн 5



Агаарын чанарын хэмжилтийн 4 суурин харуулын мэдээг тухай бүр тасралтгүй НАЧА-ны цахим хуудсаар мэдээлдэг болсон.
www.ub-air.info




2

Үр дүн

Техникийн ур чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулж боловсон хүчнийг чадавхижуулах

Баянхошуу /2016-04-28 22:00 ~ 04-30 22:00/



Агаарын чанарын мэдээг та бүхэн өөрийн байгууллагын цахим хуудас болон мэдээллийн дэлгэцээр байршуулахыг хүсвэл дараах утсаар холбоо барина уу. Утас : 318551, 314876
<http://www.air.ub.gov.mn/lcd-menu-3.html>


Баянхошуу

Тоон үзүүлэлт	Аг
0-50	Зөв
51-100	Салбар
101-250	Салбар
251-400	Салбар
401-500	Салбар
500-	Салбар

1

Үр дүн

Нийт 13 суурин харуулын хэмжилтийн дүн мэдээг цахим хуудсаар мэдээлэх болсон.



2

Үр дүн

Суурин харуулын шинэ 1 байрыг хүлээлгэн өгч ашиглалтад оруулсан

Төсөл 2-р үе шат



Үр дүн 1

УБ хотын агаар орчны хяналтын нийт 13 суурин харуулын хэмжилтийн дүн мэдээг нэгтгэн цахим хуудсаар мэдээлж олон нийтэд түгээн АЧ-ын хяналтын олон улсын сүлжээнд нэгдэн орсон. www.aqicn.org



Үр дүн 2

4 суурин харуулын тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг явуулах боловсон хүчин бэлтгэн шинэ 1 суурин харуулыг 2016 онд ашиглалтад оруулсан



Үр дүн 3

МУ-ын байгалийн нөхцөлд нийцсэн багаж тоног төхөөрөмжийг нийлүүлсэн. Зуухны магадлан итгэмжлэх ажил, авч хэрэгжүүлэх арга хэмжээний үнэлгээг хэмжилтээр хэрэгжүүлдэг болсон.



Үр дүн 4

Авто тээврийн хөдөлгөөнт үед агаарт хаягдах хорт бодисын хэмжээг тодорхойлох 2 иж бүрэн тоног төхөөрөмжийг нийлүүлсэн.



Үр дүн 5

2 тэрбум 754 сая төгрөгийн багаж төхөөрөмж нийлүүлсэн.

4.Төслийн 3-р үе шат

Төслийн хугацаа

2018 оны 6-р сарын 29-ны өдрийн НАБТГ болон БОАЖЯ-тай байгуулсан санамж бичгийн дагуу 2018 оны 11 сараас эхэлж 4.6 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр болсон.

Хэрэгжүүлэгч байгууллага

Нийслэлийн болон төрийн холбогдох яам, ажлын хэсгийн бүрэлдэхүүн /35 байгууллага/

Хамрах бүс

Улаанбаатар хот /Нийслэлийн 6 дүүрэг/

Төслийн явц

Төслийн хэрэгжилт цар тахалтай холбоотойгоор 48%-ийн гүйцэтгэлтэй байна.

Төслийн хугацаа		Гүйцэтгэлийн хугацаа	
1-р үе	2018 оны 11 сараас 2022 оны 6 сар	Дугаар -1	2018 оны 11 сараас 2019 оны 4 сар
		Дугаар-2	2019 оны 5 сараас 2019 оны 10 сар
		Дугаар-3	2019 оны 11 сараас 2020 оны 4 сар
		Дугаар- 4	2020 оны 5 сараас 2020 оны 10 сар
		Дугаар- 5	2020 оны 11 сараас 2021 оны 4 сар
		Дугаар- 6	2021 оны 5 сараас 2021 оны 10 сар
		Дугаар-7	2021 оны 11 сараас 2022 оны 4 сар
2-р үе	2022 оны 7 сараас 2023 оны 10 сар	Дугаар- 8	2022 оны 5 сараас 2022 оны 10 сар
		Дугаар- 9	2022 оны 11 сараас 2023 оны 4 сар

4.1 Төслийн ерөнхий явц

Үр дүнгийн биелэлтийн байдал /дугаар 1-4/

КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр хэрэгжилт ихээхэн хоцрогдсон тул 2023 оны 4 сар хүртэл төслийн үр дүн, шалгуурыг хангах боломжгүй гэж төслийн багаас үзсэн бөгөөд төслийн хугацааг 2024 оны 7 сар хүртэл сунгасан байдлаар ажлын төлөвлөгөөг сунгах талаар зөвлөлдөөд байна.



Биелэлт

1

Үр дүн

2018 оны 11 сараас 2020 оны 6 сар хүртэлх хугацаанд 129 байгууламжийн зууханд утааны хийн хэмжилт хийсэн. Мөн 2ш PM сорьцлогч төхөөрөмжийг нийлүүлсэн.

2

Үр дүн

Эх үүсвэрийн ялгарлын инвентор, суурин эх үүсвэрийн утааны хийн хэмжилт зэрэг техникийн ур чадварын эзэмшүүлэх сургалт цахим (Web) хэлбэрээр амжилттай зохион байгуулсан.

3

Үр дүн

Сайжруулсан хатуу түлш техникийн шаардлага(MNS 5679-2019) батлагдсан. Тус стандарт нь 2019 оны 5 сарын 15-с эхлэн мөрдөгдөөд байна.

4

Үр дүн

Хамтрагч байгууллага, хандивлагч байгууллагын оролцоо, уялдааг сайжруулсан

4.2 Сайжруулсан шахмал түлшний загвар төслийн тухай



Хамрах хүрээ

Технологийн хувьд дэвшилттэй, илүү чанартай сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх түршилтын бүтээгдэхүүн гаргах (биомасс холисон мидлинг брикет, хагас коксын мидлинг брикет)



Ялгарлын бууралтын үр дүнг баталгаажуулах

-Гэр хороолол хамрагдахгүй
 -Амралтын газрыг сонгож, хэрэгжүүлнэ
 -PM /тоосонцор/, SO₂-ын ялгарлыг НАБТГ-ын явуулын станцаар хэмжих.



Сайжруулсан шахмал түлшинд тавигдах техникийн үзүүлэлт

-Шаталтаас үүсэх хаягдал утааны хэмжилтээр PM, SO₂, CO агууламж одоогийн сайжруулсан түлшнээс бага байх.
 -Агаар орчин дахь PM агууламж буурах.
 -Хортой бодис, хүнд металлаас үүдэлтэй эрүүл мэндийн сөрөг нөлөөлөлгүй, Эрүүл ахуйн талаас шаардлага хангасан байх



Үр дүнг хэрэгжүүлэх

Сайжруулсан түлшний хэмжилтийн дүнг нэгтгэж, үнэлгээний агуулгаар сайжруулсан шахмал түлштэй хамаарал бүхий байгууллагуудтай хэлэлцэж, одоо үйлдвэрлэж буй сайжруулсан шахмал түлшний төсөлд тусгах.



4.4 Автотээврийн хэрэгслээс үүдэлтэй бохирдлыг бууруулах арга хэмжээ

Японд зохион байгуулагдах сургалтад хамруулах
Хугацаа: 2021 оны 9 сар*



Гэрлэн дохионы зохицуулалт

Гэрлэн дохионы удирдлагын системийг сайжруулах, сайжруулсан тохиолдолд ялгарлын хэмжээний бууралтад нөлөөлөх үр дүнгийн судалгаа хийх

EURO-5

Шатахууны хэрэглээ


Евро 5 шатахууны хэрэглээг нэвтрүүлэх, Авто зам ашиглалтын бүс тогтоох боломжийг судлах.

Эко жолоодлогыг нэвтрүүлэх

Эко жолоодлого, хяналтын камерийг нэвтрүүлэх хууль эрх зүйн орчинг бүрдүүлж хяналтын камер суурилуулах, төсвийг бүрдүүлэх.

Нэмэлт төхөөрөмж суурилуулах

Хүхэр багатай шатахуун, ялгарал багатай ТХ-ийн хэрэглээг нэмэгдүүлэх, нийтийн тээврийн дизель автобусанд утааны тортог шүүгч DPF, түүнийг цэвэрлэх тоног төхөөрөмж суурилуулах



Тулгамдаж буй асуудал

КОВИД-19 цар тахлын хилийн хорионы улмаас төлөвлөсөн үйл ажиллагаанд ихээхэн хоцрогдол үүссэн. 2019 онд агаарын бохирдлын эсрэг сан (АБЭС)-г татан буугдсан тул төслийн АБЭС холбоотой үйл ажиллагаа, үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг биелүүлэх боломжгүй болсон. Төсөл дуусах 2023 оны 4 сар хүртэл биелэлт хангахгүй шалгуур үзүүлэлтүүд байгаа учраас 2024 оны 7 сар хүртэл төслийн хугацааг сунгах, мөн 2021 оны 4 сард хилийн хориг цуцлагдах нөхцлөөр төслийн бүх үйл ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан.



Төсөл хэрэгжих хугацааг сунгах



ХЗХ-ны анхдугаар хуралдааны үеэр харилцан тохиролцсоны дагуу тус төсөл нь Дэлхийн Банкны “Цэвэр агаар төсөл”, бусад хандивлагч байгууллагын холбогдох төсөлтэй хамтарч уялдаатай ажиллахад НАБТГ-ын дарга голлох үүргийг гүйцэтгэж ажиллах



Төслийн баримт бичиг (Record of Discussion) ийг шинэчлэх шаардлага



Автомашинтай холбоотой загвар төслийг бодит арга хэмжээ болгох





АНХААРАЛ ХАНДУУЛСАН БАЯРЛАЛАА